



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction

ЭРДЭС НЭМЭГДЭЛ ТЭЖЭЭЛ

Малын биед дутагдаж буй эрдэс бодисын хэрэгцээг бүрэн хангахын тулд байгаль, ургамал, амьтны гаралтай болон үйлдвэрийн аргаар гаргаж авсан химийн бодис оролцуулан тусгай жороор бэлтгэж буй нэгэн жигд бүтэцтэй хольцыг эрдэс нэмэгдэл тэжээл гэнэ.

Ач холбогдол

Мал, амьтны бие махбод болон ургамалд 60 гаруй химийн элемент агуулагдаж байгааг тогтоосон байна. Эрдэс бодисууд мал, амьтны биед махбодод дан ба хам шинж байдлаар нөлөө үзүүлдэг. Эрдэс бодист кальц (Ca), фосфор (P), натри (Na), хлор (Cl), кали (K), магни (Mg), хүхэр (S), Төмөр (Fe), зэс (Cu), цайр (Zn), Кобальт (Co), Молибден (Mo), Фтор (F), Иод (J), Манган (Mn), Селен (Se) зэрэг эрдэсийг мал, амьтны мал, амьтанд нормийн дагуу нэмэгдэл тэжээл болгож өгөх нь малын ашиг шим өсөх, тарга тэвээрэг авах, элдэв өвчин эмгэгээс сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой.

Тэжээлийн жор найрлага

Манай орны нуур цөөрмийн давс, хужир, шүүний найрлаганд натри, хлор хангалттай агуулагддаг. Харин бусад эрдэс бодисуудыг тусгай жороор эрдэс нэмэгдэл тэжээлийг бэлтгэж, стандарт нормын дагуу малд өгнө. Эрдэс нэмэгдэл тэжээл нь дараах 3-н бүтэцтэй.

- Ердийн найрлагат эрдэс нэмэгдэл тэжээл (давс, хужир, шүү)
- Олон найрлагат эрдэс нэмэгдэл тэжээл; (шаарлагатай эрдэст тэжээл)
- Бүрэн найрлагат эрдэс нэмэгдэл тэжээл;

Бүрэн найрлагат эрдэс нэмэгдэл тэжээлийг дараах 3 жороор бэлтгэн ашиглаж байсан. Үүнд:

1. Нунтагласан хужир 30 кг, шүү 30 кг, давс 30 кг, ясны үнс 1 кг, аргалын үнс 3 кг-ыг хольж бэлтгэнэ.
2. Нунтагласан давс 40 кг, хужир шүүний тэнцүү хольц 60 кг, ясны үнс 1 кг, хүхэр 0.3 кг, хүхэр хүчлийн зэс 0.1 кг, хүхэр хүчлийн цайр 0.06 кг, хүхэр хүчлийн төмөр 0.04 кг, хлорлог кобальт 0.03 кг, иодлог кали 0.005 кг-ыг хольж жигдрүүлнэ.
3. Нунтагласан давс 40 кг, хужир шүүний тэнцүү хольц 60 кг, ясны үнс 1 кг, хүхэр хүчлийн зэс 0.1 кг, манган хүчлийн кали 0.03 кг, хлорлог кобальт 0.03 кг, иодлог кали 0.005 кг-ыг хольж бэлтгэнэ.

Эрдэс нэмэгдэл тэжээл бэлтгэж, ашиглах арга

Малын төрөл, нас, хүйс, ашиг шимийн онцлогт тохируулж эрдэс нэмэгдэл тэжээлийн жор боловсруулж тэжээл бэлтгэж ашиглана. Бүс нутгийн онцлог байдлыг тусгасан жор байж болно.



Хужир. Манай орны ихэнх нутагт элбэг түүхий эд болох хужирьг малын эрдэс тэжээлээр бэлтгэх ба хужир элбэгтэй газарт долоолгож болно. Хужрыг малд өгөхөд устай холилдон малын ходоодонд нүүрс хүчлийн хий үүсгэнэ. Энэ нь микро организмын амьдрах нөхцөлийг бүрдүүлж улмаар хоол тэжээлийг боловсруулах ажиллагааг сайжруулна. Хужрын найрлагын 36.65-78.99 хувийг карбонат, бикарбонат натри эзэлж байдгаас гадна зэс, цайр, иод, төмөр зэрэг микро элементүүд орох учир чанар сайтай эрдэс тэжээлд тооцогддог. Хужрыг бод малд хоногт 40-50 г, бог малд 12-15 г өгнө.



Давс. Найрлагад 97.3 хувь, хлорт натри, 0.25 хувь нь хлорт магни, 3.25 хувь нь сульфат кальц, 0.25 хувь нь бикарбонат кальци байна. Давс нь малын бодисын солилцоог идэвхжүүлэх, ходоодонд давсны хүчил бий болгон ходоодны ажиллагааг сайжруулж, уургийн шингэцийг 15-20 хувиар нэмэгдүүлдэг. Хоногт үхэрт 35-50 г, адуунд 30-40 г, бог малд 10-15 г өгнө. Давсыг бүхлээр нь тавьж долоолгох буюу нунтаглаж бусад тэжээлтэй хольж өгч болно.

Модны үнс: Кальци болон бусад бичил язгуур мах бодоор баялаг. Хусны үнсний найрлагад кальци 22.4 хувь, фосфор 2.2 хувь, натри 9.4 хувь, кали 7.2 хувь, магни 7.1 хувь, төмөр 0.8 хувь, бичил язгуур мах бодоос манган 47, цайр 0.5, зэс 0.4, альбин 0.36, иод 0.03 мг орчим агуулагддаг.



Ясны гурил: Ясыг цайвар шаргал өнгөтэй болтол шатааж нунтаглан бэлтгэнэ. Ясны үнсэнд кальци 35 хувь, фосфор 16 хувь, бичил язгуур мах бод төмөр, хүхэр, зэс, цайр нэлээд хэмжээтэй байна. Тэмээнээс 25 кг, адуу, үхрээс 15 кг, хонь, ямаанаас 3 кг гардаг. Үнсийг бага хэмжээгээр тэжээлтэй хольж ус, шөлөөр чийглээд өвлийн улиралд онгоц, саванд хийж хөлдөөж, зуны улиралд хужир, давс, хивэг, гурил, үнсийг хольж багсраад малд долоолгох боломжтой.



Шохойн чулуу. Манай улс шохойн чулууны нөөц ихтэй. Шохойн чулууг боловсруулж мал сүргийг кальциар баялаг эрдэс тэжээлээр хангах бүрэн боломжтой. Шохойн чулууны найрлагад кальци 32.6 хувь, төмөр 0.5 хувь, хүхэр 0.2 хувь орчим байна. Шохойн чулууг элс, шорооны хольцоос нь цэвэрлэн нунтагласны дараа зохих нормын дагуу малын нэмэгдэл тэжээлд хэрэглэнэ. Харин шатаагаагүй буюу шатаасан 5-6 сар болоогүй шохойн чулууг малын тэжээлд ашиглаж болохгүй.

Шүү. Шүүний найрлагын 93.19-97.9 хувийг сульфат натрийн давс эзэлдэг. Мөс шиг өнгөтэй, наранд өгөршин цагаан болж гараар имрэхэд ус болно. Шүүнд марганец, иод,

төмөр, зэс, цайр зэрэг микро элементүүд бага хэмжээгээр агуулагдана. Шүүг тосон ба мөсөн шүү гэж ялгадаг. Тосон шүүнд хужир 30-аад хувь байдаг учраас хор уршиг багатай, харин мөсөн шүүний 90 хувь сульфатын давс тул халуун дулаан үед малд их хэмжээгээр өгч болдоггүй. Харин өвлийн ид хүйтэнд малд өгөхөд тохиромжтой. Шүүг бод малд хоногт 30 г, хонинд 10 г өгнө.

Фторгүйжүүлсэн фосфат: Фосфат нэгдлийг мал сүргийг фосфор, кальцийн дутагдлаас сэргийлэх зорилгоор ашиглана. Байгалийн фосфорит нь 3.5-4 хувийн фтортой байдаг тул түүнийг шууд нунтаглан ашиглах нь малыг хордуулах аюултай. Тэжээлийн жорын хуурай бодисын 0.003 хувь нь фтор байвал мал амьтан ялангуяа гахай, үхэр зэргийг гүн хордлогод оруулахаас гадна шүдийг нь өвчлүүлж гэмтээнэ. Иймээс фосфоритыг химийн аргаар фторгүйжүүлсний дараа малд ашиглана. Фторгүйжүүлсэн фосфат нь 0.2 хувийн фтортой байх ба энэ нь ясны гурилын фторын хэмжээтэй ойролцоо юм. Малд шохой, давс зэргийг шууд дангаар нь өгдөг бол фосфатыг багсармал тэжээлд 2-3 хувьд тооцож өгдөг.

